

ЦАХИМ ИЛ ТОД БАЙДЛЫН
ИНДЕКС



2019

ТӨРИЙН БАЙГУУЛЛАГУУД



ТӨРИЙН БАЙГУУЛЛАГЫН ЦАХИМ ХУУДАСНЫ ИЛ ТОД БАЙДАЛ

ЦАХИМ ИЛ ТОД БАЙДЛЫН ИНДЕКС БОЛОН АРГА ЗҮЙ

ТӨРИЙН БАЙГУУЛЛАГУУДЫН ЦАХИМ ИЛ ТОД БАЙДЛЫН ИНДЕКС

АГУУЛГА

Оршил.....	3
1. ТӨРИЙН БАЙГУУЛЛАГЫН ЦАХИМ ХУУДАСНЫ ИЛ ТОД БАЙДАЛ.....	4
2. ЦАХИМ ИЛ ТОД БАЙДЛЫН ИНДЕКС.....	6
3. ИНДЕКСИЙН АРГА ЗҮЙ.....	8
Индексийн бүтэц.....	8
Ашиглагдсан мэдээллийн тухай.....	9
Цахим ил тод байдлын индексийн онооны тайлбар.....	10
4. ҮР ДҮН.....	11
Индексийн үр дүн – Улсын түвшинд.....	11
Индексийн үр дүн – Байгууллагын түвшинд.....	13
Яамдын цахим ил тод байдал.....	14
Хэрэгжүүлэгч агентлагийн цахим ил тод байдал.....	15
Тохируулагч агентлагийн цахим ил тод байдал.....	16
Аймгийн засаг даргын тамгын газрын цахим ил тод байдал.....	17
Дүүргийн засаг даргын тамгын газрын цахим ил тод байдал.....	19
Парламентын харьяа байгууллагын цахим ил тод байдал.....	20
5. ДҮГНЭЛТ, САНАЛ ЗӨВЛӨМЖ.....	21
Хууль эрх зүйн орчин.....	21
Байгууллагын чадамж.....	21
Цахим нээлттэй байдал.....	22
ХАВСРАЛТ.....	24
Хавсралт 1. Дэлгэрэнгүй арга зүй.....	24
Хавсралт 2. Нийт төрийн байгууллагын эрэмбэ.....	26

ОРШИЛ

Хараат бус судалгааны хүрээлэн 2010 оноос хойш төрийн байгууллагын цахим хуудасны ил тод байдлыг үнэлэх зорилгоор 'Төрийн байгууллагын цахим хуудасны ил тод байдал' мониторинг судалгааг гүйцэтгэсээр ирсэн билээ. Энэхүү мониторинг судалгаа нь төрийн байгууллагуудын цахим хуудас хэрхэн сайжирч, эсвэл хэрхэн муудаж буйг үнэлж, тогтмол сайжруулахад нь хөшүүрэг болох үндсэн зорилготойгоор хэрэгжиж ирсэн. Харин 2019 онд уг үнэлгээг олон улсын түвшний индекс болгох зорилго өвөрлөн судалгааны аргагүйгээ шинэчилж, төрийн байгууллагын 'Цахим ил тод байдлын индекс'-ийг боловсрууллаа. Уг индексийн анхны туршилтыг Монгол болон Киргизстан улсад амжилттай зохион байгуулсан. Энэхүү тайланд Монгол Улсын яамд болон тэдгээрийн харьяа хэрэгжүүлэгч, тохируулагч агентлагууд зэрэг нийт XX (тоо тавих) төрийн байгууллагуудын цахим ил тод байдлыг шинэчилсэн аргагүйгээр үнэлж, гарсан үр дүнд үндэслэн байгууллага бүрийн цахим ил тод байдлын өнөөгийн нөхцөлийг индексжүүлэн тодорхойллоо.

Ил тод байдал гэж юу вэ?

Ил тод байдал нь сайн засаглалын нэг хэсэг бөгөөд хууль эрх зүйн орчныг бүрдүүлэхэд чухал үүрэг гүйцэтгэдэг. Үүнийг тогтвортой хэрэгжүүлбэл авлигатай тэмцэх, засаглалыг сайжруулах, төр, иргэд болон бусад оролцогч талуудын үүрэг хариуцлагыг нэмэгдүүлэх боломжтой юм. Тодруулбал, төр олон нийтэд үйл ажиллагаагаа нээлттэй хүргэснээр иргэд цаг тухайд нь үнэн зөв мэдээллийг авч, төрийн үйл ажиллагааг үр ашигтайгаар хянаж, төр засагт хариуцлага тооцоход суралцана. Тиймээс мэдээллийг ил тодоор олон нийтэд хүргэх нь нэн тэргүүнд тавигдах шаардлагатай чухал асуудал юм.

Цахим ил тод байдал гэж юу вэ?

Цахим ил тод байдал гэдэг нь мэдээллийг цахим хэлбэрээр нээлттэй, хүртээмжтэй хүргэхийг хэлнэ. Орчин үеийн мэдээлэл харилцааны технологи (МХХТ)-ийг ашиглах нь ил тод байдлыг бүхэлд нь сайжруулах суурь хүчин зүйл болдог. Цахим засаглалын хамгийн тохиромжтой хэлбэр нь засгийн газрын бүх салбар, нэгж хоорондоо харилцан уялдаатай ажиллаж, иргэн, аж ахуйн нэгжүүдэд нэг цонхоор, тэгш үйлчилгээ үзүүлэх явдал юм. Цахим засаглалын гол давуу тал нь дотоод үр ашгаа сайжруулахын сацуу төрийн байгууллагын гадаад ил тод байдлыг нэмэгдүүлэхэд оршдог. Цахим засаглалыг хэмждэг хэд хэдэн индекс байдаг бөгөөд тэдгээрийн зарим нь цахимаар үзүүлж буй хувь нэмэр оруулах нь гарцаагүй юмүйлчилгээний төрлөөр ил тод байдлын түвшнийг шууд хэмждэг бол зарим нь хандалтын түвшин, хүний нөөцийн хөгжил гэх мэт үзүүлэлтүүдийг хэмждэг ажээ.

МХХТ хэрэглээ жилээс жилд өсөж байгаа бөгөөд 2010 онд дэлхий даяар 1.9 тэрбум хүн МХХТ-ийг хэрэглэж байсан бол 2016 онд энэ тоо 3.3 тэрбум болтол өсжээ. Нийгмийн салбар бүрд МХХТ-ийн дэвшилд дасан зохицох, нийцэх сорилт тулгарч байгаа бөгөөд ялангуяа төрийн үйлчилгээнд инновацлаг өөрчлөлтүүд дутагдаж байна.

Нэг талаас хувьсан өөрчлөгдөж буй даяаршил, нөгөөтэйгөөр иргэд болон оролцогч талуудын төрийн үйлчилгээний талаарх мэдээлэл ба ил тод байдлыг улам бүр нэмэгдүүлэх эрэлт хэрэгцээ нь МХХТ-ийн шийдлүүдийг ашиглан төрийн үйлчилгээг хүргэхийг шаардаж байна.

МХХТ-ийн хөгжлийн хамгийн чухал хэсэг нь газар зүйн байршлаас үл хамааран төрийн байгууллагын ил тод байдлыг хангах, мэдээлэл авах эрхийг сурталчлахад хувь нэмэр оруулах явдал юм. Нэгдсэн Үндэсний Байгууллагын 2018 оны цахим засаглалын судалгааны тайланд цахим хэрэглээ нь нийгмийн оролцоог нэмэгдүүлж, төрийн үйлчилгээний зардлыг багасгадаг болохыг тогтоожээ. Тиймээс дижиталчлал нь төрийн шийдвэр гаргалт дахь иргэний орон зай ба оролцоог нэмэгдүүлэхэд хувь нэмэр оруулах нь гарцаагүй юм.


1. ТӨРИЙН БАЙГУУЛЛАГЫН ЦАХИМ ХУУДАСНЫ ИЛ ТОД БАЙДАЛ

'Цахим ил тод байдлын индекс'-ийг тодорхойлохын өмнө төрийн байгууллагын цахим хуудасны ил тод байдлын мониторингийн 2010-2018 оны үр дүнг нэгтгэн авч үзье. Төрийн байгууллагын цахим хуудасны ил тод байдлын мониторинг нь хөндлөнгийн үнэлгээ бөгөөд төрийн байгууллагын цахим хуудасны мэдээллийн ил тод байдлыг (i) үйл ажиллагааны хувьд, (ii) хүний нөөцийн хувьд, (iii) төсөв санхүүгийн хувьд, (iv) худалдан авах ажиллагааны хувьд тус тус үнэлдэг. Ингэхдээ мэдээллийг холбогдолтой эсэх, найдвартай эсэх, цаг хугацаандаа нийтлэгдсэн эсэх, хүртээмжтэй эсэх, хэрэглэхэд хялбар эсэхийг хамардаг. Үүнээс гадна шалгуур үзүүлэлт бүрийг хэдэн хувьтай биелүүлснээс хамаарч төрийн байгууллагын цахим хуудасны ил тод байдлыг “Хаалттай”, “Зарим талаар ил тод”, “Ил тод”, “Бүрэн ил тод” гэсэн 4 түшингээр үнэлэн үр дүнг гаргадаг.

Цахим хуудасны мониторинг хийснээс хойших есөн жилийн хугацаанд төрийн байгууллагуудын цахим хуудасны мэдээллийн агуулга, хүртээмж жилээс жилд сайжирсан бөгөөд уг үнэлгээний үр дүн нь төрийн байгууллагуудыг цахим хуудсаа сайжруулах гол хөшүүрэг болсон юм. 2010 онд судалгаанд хамрагдсан 81 төрийн байгууллагын зөвхөн 17.7 хувь нь *ил тод* цахим хуудастай хэмээн үнэлэгдэж байсан бол 2018 онд уг үзүүлэлт 52.8 хувьд хүрч даруй 35 хувиар сайжирсан байна. Тодруулбал, хоёр төрийн байгууллага тутмын нэгийг ил тод цахим хуудастай хэмээн дүгнэж болохоор байна.

Гэхдээ сүүлийн 4 жилийн хугацаанд *ил тод* цахим хуудастай төрийн байгууллагын тоо төдийлөн өсөхгүй байна. Төрийн байгууллагуудын цахим хуудас иргэдэд нээлттэй мэдээллүүдийг оруулах зорилго бүхий цэсүүдийг байршуулсан ч доторх мэдээллийг тогтмол шинэчилдэггүй, мэдээллийг бүрэн байршуулаагүй зэрэг нийтлэг дутагдлууд ажиглагдсаар байна.

Зураг 1. Ил тод цахим хуудас бүхий төрийн байгууллагын хувь, 2010-2018 он (N=81)



Эх сурвалж: Төрийн байгууллагын цахим хуудасны ил байдлын мониторинг судалгаа, 2010-2018 он

Төрийн байгууллагын цахим хуудасны ил тод байдлыг байгууллагын төрлөөр нь үзвэл яамд болон хэрэгжүүлэгч агентлагуудын цахим хуудасны ил тод байдал сүүлийн 2 жилийн байдлаар сайжирсан байна. Тухайлбал, 2018 онд яамд болон хэрэгжүүлэгч агентлагуудын 60 орчим хувь нь ил тод цахим хуудастай хэмээн үнэлэгджээ. Харин ил тод цахим хуудастай аймаг, дүүргийн ЗДТГ-уудын тоо 2018 онд өмнөх оноос даруй 7-9 хувиар буурсан байна.

Хүснэгт 1. Ил тод цахим хуудас бүхий төрийн байгууллагын хувь, байгууллагын төрлөөр

№	Байгууллагын төрөл	Нийлбэр оноо	
		2017	2018
1	Монгол Улсын яамд	51.5	59.3
2	Хэрэгжүүлэгч агентлагууд	54.1	59.7
3	Тохируулагч агентлагууд	51.8	48.8
4	Аймгуудын Засаг даргын тамгын газар	60.4	51.0
5	Дүүргүүдийн Засаг даргын тамгын газар	53.5	45.8
6	Парламентын харьяа байгууллагууд	50.7	48.0
Ерөнхий дундаж		54.6	52.9

Эх сурвалж: Төрийн байгууллагын цахим хуудасны ил байдлын мониторинг судалгаа, 2017 ба 2018 он

2. ЦАХИМ ИЛ ТОД БАЙДЛЫН ИНДЕКС


Цахим ил тод байдлын индекс нь цахим мэдээллийг нийтлэхийн давуу, сул талыг илрүүлэх зорилгоор улс орны болон төрийн байгууллагын цахим ил тод байдлыг үнэлж, тоон үзүүлэлтээр харьцуулан гаргаж буй үзүүлэлт юм. Цахим ил тод байдлын үнэлгээгээр улс орнууд эсвэл байгууллагуудыг хооронд нь харьцуулж байгаа ч энэ нь тэдгээрийн ил тод байдлыг бүрэн илэрхийлэхүйц үнэмлэхүй хэмжүүр биш гэдгийг цохон тэмдэглэх нь зүйтэй юм. Харин уг харьцуулсан шинжилгээний үр дүнд үндэслэн байгууллагууд өөрсдийн даваа болон сул талаар гүнзгий ойлголттой болох зорилгоор индексийг ашиглах хэрэгтэй. Уг индексийн гол зорилго нь орчин үеийн МХХТ-ийг ашиглан мэдээллийг ил тод нийтлэхтэй холбоотой системийг бүхэлд нь сайжруулахад хувь нэмэр оруулах явдал юм. Индексийг төрийн байгууллага эсвэл бусад төрлийн байгууллага бие биеэсээ суралцах, цахим мэдээлэл түгээхэд тулгарч буй ололт ба бэрхшээлийг тодорхойлох, энэ чиглэлээр баримталж буй бодлого, стратегийг боловсруулахад ашиглаж болно.

Түүнчлэн уг индекс төрийн байгууллага, тэдгээрийн нэгжүүдийн цахим мэдээлэл түгээхтэй холбоотой асуудалд түлхэц үзүүлэх, ил тод ба нээлттэй байх соёлыг хөгжүүлэхэд цахим мэдээллийн ил тод байдал хэрхэн чухал үүрэг гүйцэтгэдгийг мэдээлэх үүрэгтэй юм. Индексийг төрийн удирдлага, цахим засаглал, ил тод байдал, МХХТ-ийн чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй хэн боловч ашиглах боломжтой. Уг индекс нь ил тод байдлыг гурван үндсэн бүрэлдэхүүн хэсгийн хүрээнд авч үзсэн.

Үүнд:

- Эрх зүйн орчин
- Байгууллагын чадамж
- Цахим нээлттэй байдал

Зураг 2. Төрийн байгууллагын цахим ил тод байдлын мөчлөг



Эрх зүйн орчны бүрэлдэхүүн хэсэг нь тухайн улс орны мэдээллийн ил тод байдлын эрх зүй, бодлогын орчныг үнэлнэ. Тодруулбал, тухайн улс оронд төрийн байгууллагыг мэдээллээ ил тод, нээлттэй болгох нөхцөлийг хэрхэн хангаж байгаа талаар дэлгэрэнгүй авч үзнэ. Зарим тохиолдолд бодлого, засаглалын орчин ил тод байдлыг хангахад саад учруулдаг. Түүнчлэн энэ хэсэгт ил тод байдлыг эрэлтийн талаас нь буюу тухайн улсад иргэний нийгэм болон иргэдийн оролцооны хөгжил ямар түвшинд байгааг авч үзнэ.

Эрх зүйн орчны бүрэлдэхүүн хэсэг, түүнд харгалзах индикаторууд нь улсын түвшинд үнэлэгдэхийн сацуу зарим салбарын шинжтэй үзүүлэлтүүдийг хамарна.

Байгууллагын чадамжийн бүрэлдэхүүн хэсэг нь ил тод байдлыг хэрэгжүүлэхэд байгууллагын чадавх бүрдсэн эсэхийг үнэлнэ. IRIM судалгааны хүрээлэнгийн “Төрийн байгууллагын цахим хуудасны мэдээллийн ил тод байдал” мониторингийн үр дүнгээр ил тод байдлын түвшин, мэдээллийн нээлттэй байдал нь байгууллагын чадавх, нөөцөөс ихээхэн хамаардаг болох нь тогтоогдсон. Ил тод байдлын шалгуурыг дагаж мөрдөж байгаа байгууллагуудад мэдээллийг хэрхэн ил тод болгох талаар тодорхой процесс төдийлөн байдаггүй. Түүнчлэн ил тод байдлыг тасралтгүй, тогтвортой авч явах хүний нөөц, бусад шаардлагатай нөөц ч хомс байдаг. Тиймээс энэхүү бүрэлдэхүүн хэсэг нь тухайн байгууллагад (i) мэдээллийг ил тод болгох үйл ажиллагааны процедур бүрдсэн эсэх, (ii) мэдээллийг ил тод болгоход шаардагдах нөөц хүрэлцээтэй эсэх, (iii) нээлттэй мэдээллийн санг үүсгэх болон тогтвортой авч явах чадвар байгаа эсэх, (iv) мэдээллийг ил тод болгоход технологийн хэрэгслийг ашиглах чадвар байгаа эсэх зэргийг үнэлнэ. Эдгээр үзүүлэлтийг авч үзсэнээр байгууллагын чадавхтай холбоотой ямар бэрхшээл тулгарч байгааг тодорхойлохын сацуу ил тод байдлыг илүү сайн хангахын тулд юуг сайжруулах талаар тодорхойлох боломж бүрдэнэ.

Цахим нээлттэй байдал бүрдэлдэхүүн хэсэг нь цахим хэрэгслээр нээлттэй болгож буй мэдээллийн хэмжээ, цар хүрээг үнэлнэ. Ингэхдээ төрийн байгууллагын цахим хуудсаараа нийтэлж буй мэдээллийн агуулга нь Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хууль болон бусад холбогдох дүрэм журамтай хэр нийцэж байгаад төвлөрнө.

Ач холбогдлын хувьд уг индекс нь төрийн байгууллагын цахим засаглалыг бүхэлд нь үнэлдэг цор ганц индекс бөгөөд олон улсын түвшинд болон тухайн нэг улсын түвшинд ашиглаж болохуйцаар боловсруулагдсан. Индексийн гол онцлог нь зөвхөн мэдээллийн ил тод байдлыг үнэлэх бус мэдээллийн нээлттэй байдлыг сайжруулахад шаардлагатай эрх зүй, бодлогын орчин бүрдсэн эсэх, иргэний нийгэм нь уг асуудлаар идэвх оролцоотой байдаг эсэхийг цогцоор нь хэмжихээс гадна тухайн төрийн байгууллагад мэдээллийг ил тод болгох чадавх, нөөц, механизм бүрдсэн эсэхийг үнэлэх явдал юм.


3. ИНДЕКСИЙН АРГА ЗҮЙ

Индексийн бүтэц

Цахим ил тод байдлын индекс нь нэгдмэл нэг оноогоор илэрхийдэгдэх бөгөөд энэ нь эрх зүйн орчин, байгууллагын чадамж, цахим нээлттэй байдал гэсэн 3 бүрэлдэхүүн хэсэгтэй. Эдгээр бүрэлдэхүүн хэсгүүд нь 9 дэд бүлэг, 26 индикатораас бүрдэнэ. Цахим ил тод байдлын индексийн бүтцийг Зураг 3-т үзүүлэв.

Зураг 3. Цахим засаглалын индексийн бүтэц

ЦАХИМ ИЛ ТОД БАЙДЛЫН ИНДЕКС



Ашиглагдсан мэдээллийн тухай

Цахим ил тод байдлын индексийг тооцоход ашиглагдах мэдээлэл нь бүрэлдэхүүн хэсэг бүрийн хувьд ялгаатай учраас өөр өөр эх үүсвэрээс цуглуулсан.

Эрх зүйн орчны бүрэлдэхүүн хэсгийн хувьд мэдээллийг улсын түвшинд цуглуулах бөгөөд энэ нь бүх байгууллагын хувьд нэгэн ижил ашиглагдана. Мэдээлэл авах эрх дэд бүлгийн хүрээнд мэдээлэл авах эрхтэй холбоотой хууль эрх зүй болон бодлогын баримт бичгийг үнэлсэн бол Засаглал, Иргэнийн нийгэм гэсэн дэд бүлгийн хэсэгт олон улсын нээлттэй мэдээллийн сангаас зохих мэдээллийг цуглуулж ашиглав. Тодруулбал, Дэлхийн засаглалын индекс, Иргэдийн оролцооны индекс, Дэлхийн хэвлэлийн эрх чөлөөний индекс, Иргэний нийгмийн төлөв байдлын мэдээллийг ашиглаж, нэг хэмжүүрт шилжүүлэн индикаторуудыг гаргав.

Байгууллагын чадамжийн бүрэлдэхүүн хэсгийн хувьд 72 төрийн байгууллагын холбогдох албан хаагчдаас ярилцлага хийх замаар тухайн байгууллагын мэдээллийг ил тод болгох тухайн байгууллагын чадамжтай холбоотой мэдээллийг цуглууллаа. Өөрөөр хэлбэл мэдээллийг ил тод болгох бэлэн байдал, хариуцлага, МХХТ-ийн бэлэн байдал гэсэн 3 дэд бүлгийн хүрээнд мэдээллийг цуглуулсан.

Цахим ил тод байдал бүрэлдэхүүн хэсгийн хувьд 72 төрийн байгууллагын цахим хуудасны ил тод байдлыг үнэлж, мэдээллийг цуглууллаа. Ингэхдээ төрийн байгууллагын цахим хуудсаараа нийтэлж буй мэдээллийн хэрэгцээ шаардлага, агуулга болон хэрэглэгчдэд хүртээмжтэй байдлыг Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хууль болон бусад холбогдох дүрэм журамтай нийцүүлж үнэлсэн. Түүнчлэн технологийн нийцтэй ба үр ашигтай байдлыг харгалзан үзэв.

Цахим ил тод байдлын индексийн онооны тайлбар

Индекс нь 0-ээс 1-ийн хооронд утга авах бөгөөд индексийн утга 1 рүү дөхөх тусам төрийн байгууллагуудын цахим ил тод байдал сайн байгааг, харин 0 рүү ойртох тусам хангалтгүй эсвэл муу байгааг харуулна. Цахим ил тод байдлын индексийн үр дүнгийн утгыг доорх хүснэгтэд нэгтгэн харууллаа.

Зураг 4. Индексийн үр дүнгийн утгын ангилал

Сайн	≥ 0.80	Цахим ил тод байдлыг бий болгох, сайжруулахтай холбоотой бодлого, баримт бичгүүдийг боловсруулж, хэрэгжилтийг маш сайн хангасан. Байгууллага мэдээллийг цахимаар нийтлэх процедур, нөөц, хариуцлагыг бүрэн бэхжүүлсэн.
Хангалттай	0.65-0.79	Цахим ил тод байдлыг бий болгох, сайжруулахтай холбоотой <i>ихэнх</i> бодлого, баримт бичгүүдийг боловсруулж, хэрэгжилтийг хангасан. Гэхдээ зарим чиглэлд ахиц дэвшил гаргах шаардлагатай. Байгууллага мэдээллийг цахимаар нийтлэх процедур, нөөц, хариуцлагыг бэхжүүлж байгаа.
Сул	0.50-0.64	Цахим ил тод байдлыг бий болгох, сайжруулахтай холбоотой суурь баримт бичигтэй ч, тохирсон бодлого, стратеги байхгүй, хэрэгжилт сул. Байгууллагад мэдээллийг цахимаар нийтлэх процедур, нөөц, хариуцлага байгаа ч ил тод байдлыг цаашид тогтвортой хангах чадавхыг зарим талаар бэхжүүлэх шаардлагатай.
Хангалтгүй	0.35-0.49	Цахим ил тод байдлыг бий болгох, сайжруулахтай холбоотой бодлого, баримт бичиг <i>байхгүй</i> . Байгууллагад мэдээллийг цахимаар нийтлэх талаар <i>суурь түвшний</i> процедур, нөөц, хариуцлагатай, гэхдээ ил тод байдлыг цаашид тогтвортой хангах чадвар хомс байна.
Муу	≤ 0.35	Цахим ил тод байдлыг бий болгох, сайжруулахтай холбоотой бодлого, баримт бичиг <i>байхгүй</i> . Байгууллагад мэдээллийг цахимаар нийтлэх процедур, нөөц, хариуцлага <i>бараг байхгүй</i> , энэ нь эргээд цахим хуудас/хэрэгслээр мэдээллийг түгээхгүй байхад гол нөлөө үзүүлж байгаа.

4. ҮР ДҮН

Индексийн үр дүн улсын түвшинд

ТМонгол Улсын хэмжээнд үйл ажиллагаа явуулж буй, шийдвэр гаргах түвшний 72 төрийн байгууллагын хувьд индексийн үр дүнг нэгтгэн тооцлоо. Нийт 12 яам, 17 хэрэгжүүлэгч агентлаг, 9 тохируулагч агентлаг, 19 аймгийн засаг даргын тамгын газар, 7 дүүргийн засаг даргын тамгын газар, 9 парламентын харьяа байгууллагууд хамрагдсан. Цахим ил тод байдлын индексийн нэгдсэн оноо **улсын хэмжээнд 0.612** гарсан нь төрийн байгууллагуудын цахим ил тод байдал нийтээрээ сул түвшинд байгааг харуулж байна. Тодруулбал, Монгол улсын төрийн байгууллагуудын хувьд цахим ил тод байдлыг бий болгох, сайжруулахтай холбоотой үндсэн баримт бичиг байгаа ч, бодлого, стратеги нь тохиромжгүй, хэрэгжилт сул байна хэмээн дүгнэж болохоор байна. Түүнчлэн төрийн байгууллагуудад мэдээллийг цахимаар нийтлэх процедур, нөөц, хариуцлага байгаа ч ил тод байдлыг цаашид тогтвортой хангах чадавхыг зарим талаар бэхжүүлэх шаардлагатай нь харагдаж байна.

Бүрэлдэхүүн хэсгүүдээр авч үзвэл МУ-ын цахим ил тод байдлын индексийн нэгдсэн оноонд *байгууллагын чадамж* болон *эрх зүйн орчин* гэсэн бүрэлдэхүүн хэсгүүдийн хувь нэмэр их байв. Тодруулбал, байгууллагын чадамж ба эрх зүйн орчны бүрэлдэхүүн хэсгүүд тус бүр хангалттай түвшинд үнэлэгдсэн бол цахим нээлттэй байдлын бүрэлдэхүүн сул түвшинд үнэлэгдлээ.

Зураг 5. Цахим ил тод байдлын индекс-улсын түвшинд, бүрэлдэхүүн хэсгүүдээр

ЭРХ ЗҮЙН ОРЧНЫ 0.657			БАЙГУУЛЛАГЫН ЧАДАМЖ 0.661		ЦАХИМ ИЛ ТОД БАЙДАЛ 0.518			
МЭДЭЭЛЭЛ АВАХ ЭРХ 0.274 Мэдээлэл авах эрх 1.000 Мэдээллийн хүрээ 0.917 Мэдээлэл хүсэх процедур 0.750	ЗАСАГЛАЛ 0.172 Хуулийн хэрэгжилт 0.463 Дуу хоолой ба хариуцлага 0.640 Зохицуулалтын чанар 0.493	ИРГЭНИЙ НИЙГЭМ 0.210 Иргэдийн ороцоо 0.673 Хэвлэл мэдээллийн эрх чөлөө 0.721 Иргэний нийгмийн төлөв байдал 0.500	БАЙГУУЛЛАГЫН БЭЛЭН БАЙДАЛ 0.239 Ил тод байдлыг хангах процедур ба процесс 0.813 Нөөцийн хүрэлцээ 0.618	ҮҮРЭГ ХАРИУЦЛАГА 0.172 Манлайлал 0.642 Тасралтгүй хөгжил ба суртал 0.396	МХТ-ийн АШИГЛАЛ 0.249 МХТ-ийн ашиглалт 0.700 МХТ-ийн хүрэлцээ 0.742 Мэдээллийн санг үүсгэх, засварлах чадвар 0.811	ТЕХНОЛОГИ 0.080 Технологийн нийцтэй байдал 0.749 Технологийн үр нөлөөтэй байдал 0.447	НЭЭЛТТЭЙ МЭДЭЭЛЛИЙН АГУУЛГА 0.403 Үйл ажиллагаа 0.715 Хүний нөөц 0.439 Төсөв санхүү 0.507 Худалдан авах ажиллагаа 0.320 Нээлттэй өгөгдөл 0.639	ИРГЭДИЙН ОРЛОЦОО БА ХАРИЛЦАА 0.035 Харилцаа ба эргэх холбоо 0.523

Эрх зүйн орчны бүрэлдэхүүн хэсэг нь 3 дэд бүлэг 11 индикатораас бүрдэх бөгөөд 0.657 оноо авч, *хангалттай* түвшинд үнэлэгджээ. Уг бүрэлдэхүүн хэсгийн хувьд **мэдээлэл авах эрхийн** индикаторууд харьцангуй сайн үнэлэгдсэн нь МУ-д мэдээллийн ил тод байдал, мэдээлэл авах эрхийн эрх зүйн орчин тодорхой түвшинд бүрдсэнийг харуулж байна. Гэхдээ *мэдээллийн санхүү болон хамгаалалтын* асуудал сул түвшинд байна. Харин **засаглалын** индикаторуудын дийлэнх нь хангалтгүй түвшинд үнэлэгджээ. Тодруулбал, засаглалыг үнэлэхдээ Дэлхийн Банкны-Дэлхийн засаглалын индекс"-ийн 4 бүрэлдэхүүн хэсгийг авч ашигласнаас *хуулийн хэрэгжилт, зохицуулалтын чанар, засгийн газрын үр нөлөө* хангалтгүй түвшинд байна. **Иргэний нийгмийн** индикаторууд ерөнхийдөө хангалттай түвшинд байгаа ч *иргэний нийгмийн төлөв байдал, төлөвшил* сул байна. Энэ нь эргээд төрийн байгууллагуудыг ил тод байлгах талаар иргэний нийгмийн зүгээс эрэлтийг үүсгэдэггүй, идэвхгүй байдгийг харуулж байна.

Байгууллагын чадамжийн бүрэлдэхүүн хэсэг 3 дэд бүлэг 7 индикатораас бүрдэх бөгөөд 0.661 оноо авч, *хангалттай* түвшинд үнэлэгджээ. **Байгууллагын бэлэн байдлыг** илэрхийлэх индикаторуудаас байгууллагын *ил тод байдлыг хангах процедур, процесс* сайн гэж үнэлэгдсэн бол *нөөцийн хүрэлцээ* сул байна. Тодруулбал, төрийн байгууллагуудын хувьд мэдээллийг ил тод болгох механизм бүрдсэн ч мэдээллийг ил тод байдлыг хариуцсан орон тооны ажилтангүй, эсвэл бусад ажил үүрэгтэй хавсран хийдэг, мэдээллийг ил тод болгохтой холбоотой төсөв хөрөнгө дутмаг, ашигладаг цахим платформын хүртээмж сул байгаа зэрэг нийтлэг асуудлууд байна.

Харин **үүрэг хариуцлагыг** илэрхийлэх индикаторуудаас *манлайлал* сул гэж үнэлэгдсэн бол *тасралтгүй хөгжил ба сургалт* хангалтгүй байна. Тодруулбал, төрийн байгууллагууд мэдээллийг ил тод болгохтой холбоотой үйл ажиллагааны төлөвлөгөөг боловсруулж, мөрдөх, удирдах түвшний ажилтнууд мэдээллийг нээлттэй болгох талаар манлайлах, мэдээллийн ил тод байдлын талаарх иргэдийн санал гомдлыг онлайн-аар авч, эргэн хариулах зэрэг асуудлууд сул байна. Түүнчлэн холбогдох ажилчдыг МХХТ болон цахим ил тод байдлын чиглэлээр сургах, мэргэшил дээшлүүлэх, цахим ил тод байдлын чиглэлээр хийсэн ажлын гүйцэтгэлээ тогтмол үнэлэх, үнэлгээнд суурилан ажлын төлөвлөгөөгөө сайжруулах зэрэг асуудлууд хангалтгүй байна.

МХХТ-ийн бэлэн байдлын индикаторууд хангалттай болон сайн гэж үнэлэгдсэн нь бүрэлдэхүүн хэсгийг хангалттай түвшинд үнэлэгдэхэд чухал нөлөө үзүүлээ. Тодруулбал, төрийн байгууллагуудын хувьд мэдээллийг ил тод болгох платформууд (вэбсайт, нийгмийн цахим сүлжээ, аппликейшн гм), компьютер ба интернэтийн ашиглалт хангалттай байхын сацуу МХХТ-ийн хүрэлцээ, мэдээллийн сан үүсгэх чадавх зэрэг нь хангалттай сайн түвшинд байна.

Цахим нээлттэй байдлын бүрэлдэхүүн хэсэг 3 дэд бүлэг 8 индикатораас бүрдэх бөгөөд 0.518 оноо авч, сул түвшинд үнэлэгджээ. 8 индикатораас зөвхөн 2 индикатор хангалттай түвшинд үнэлэгдсэн бол үлдсэн индикаторууд сул ба хангалтгүй түвшинд үнэлэгджээ. **Технологийн** хувьд төрийн байгууллагуудын цахим хуудасны *технологийн нийцэл* хангалттай гэж үнэлэгдсэн бол *технологийн үр ашигт байдал* сул байна. Тодруулбал, төрийн байгууллагуудын цахим хуудас ямар ч веб хөтөч болон хэрэгслийн хувьд нийцэн ажилладаг, хайхад хялбархан олддог, хурд нь боломжийн түвшинд байна. Харин цахим хуудаснаас мэдээллийг хайж олох, гадаад хэлний сонголт, мэдээллийг гадаад хэл дээр нийтлэх асуудал сул байна.

Харин төрийн байгууллагуудын нийтлэх ёстой **мэдээллийн агуулгын** хувьд *үйл ажиллагааны* талаарх мэдээлэл ихэнх вэбсайт дээр хангалттай байгаа бол *хүний нөөц, төсөв санхүү, худалдан авах ажиллагаа, нээлттэй өгөгдлийн* мэдээлэл хангалтгүй байна. Түүнчлэн вэбсайтаараа иргэдийн санал гомдлыг хүлээн авах, хариу өгч шийдвэрлэх явдал хангалтгүй байна.

Индексийн үр дүн - байгууллагын түвшинд

Энэ хэсэгт индексийн үр дүнг байгууллагын түвшинд авч үзнэ. Индексийн нэгдсэн оноогоор харьцуулахад дүүргүүдийн Засаг даргын тамгын газар хамгийн өндөр буюу 0.681 оноо авч, байгууллагын ангиллын төрөлд тэргүүлжээ. Тэргүүлэхэд нөлөөлсөн гол хүчин зүйл нь цахим нээлттэй байдлын оноогоор бусдаас түрүүлсэн явдал юм. Тухайлбал, Чингэлтэй дүүргийн ЗДТГ-ын цахим хуудсанд (i) үйл ажиллагаа, (ii) хүний нөөц, (iii) төсөв, санхүү, (iv) төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ, худалдан авах үйл ажиллагааг хамгийн нээлттэйгээр нийтэлжээ.

Хүснэгт 2 Индексийн үр дүн, байгууллагын ангиллаар

№	Байгууллагын төрөл	Индексийн нэгдсэн оноо	Эрх зүйн орчин	Байгууллагын чадамж	Цахим нээлттэй байдал
1	Дүүргүүдийн ЗДТГ	0.630	0.657	0.681	0.551
2	Монгол улсын яамд	0.627		0.692	0.532
3	Парламентын харьяа байгууллагууд	0.626		0.745	0.474
4	Аймгуудын ЗДТГ	0.618		0.661	0.529
5	Хэрэгжүүлэгч агентлагууд	0.599		0.622	0.521
6	Тохируулагч агентлагууд	0.579		0.582	0.496
Ерөнхий дундаж		0.612	0.657	0.661	0.518

Харин тохируулагч агентлагуудын ил тод байдлын индекс хамгийн бага буюу 0.598 байна. Эдгээрийн байгууллагууд *байгууллагын чадамж* болон *цахим нээлттэй байдал* гэсэн 2 бүрэлдэхүүний хувьд хамгийн багаар үнэлэгджээ. Тухайлбал, Шударга өрсөлдөөн хэрэглэгчийн төлөө газрын цахим ил тод байдлын индекс хамгийн бага буюу 0.426 оноогоор үнэлэгдсэн байна.

Бүрэлдэхүүн хэсгүүдээр авч үзвэл парламентын харьяа байгууллагуудын *байгууллагын чадамж* хамгийн өндрөөр үнэлэгдсэн бол дүүргүүдийн ЗДТГ-ын *цахим нээлттэй байдал* хамгийн өндөр оноо авчээ.

Судалгаанд хамрагдсан 72 байгууллагыг цахим ил тод байдлын индексээр нь эрэмбэлэн жагсаахад Дундговь аймгийн ЗДТГ, Өвөрхангай аймгийн ЗДТГ, ХХААХҮЯ 0.774, 0.769, 0.753 оноогоор эхний 3 байрт тус тус жагсаж байна.

Яамдын цахим ил тод байдал

Нийт 12 яамны хувьд цахим ил тод байдлыг үнэлсэн бөгөөд яамны ангилал дотроо ХХААХҮЯ 0.753 оноогоор тэргүүлж байна. Нийт 3 яамны цахим ил тод байдал хангалттай түвшинд байгаа бол үлдсэн 9 яамны цахим ил тод байдал сул байна.

Хүснэгт 4 Индексийн үр дүн, яамдаар

Эрэмбэ	Яамд	Оноо
1	Хүнс хөдөө аж ахуй хөнгөн үйлдвэрлэлийн яам	0.753
2	Сангийн яам	0.732
3	Эрүүл мэндийн яам	0.667
4	Зам тээврийн хөгжлийн яам	0.665
5	Эрчим хүчний яам	0.655
6	Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын яам	0.639
7	Уул уурхай хүнд үйлдвэрлэлийн яам	0.624
8	Гадаад хэргийн яам	0.597
9	Хууль зүй дотоод хэргийн яам	0.568
10	Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам	0.556
11	Байгаль орчин, аялал жуулчлалын яам	0.556
12	Барилга, хот байгуулалтын яам	0.517
Яамдын дундаж оноо:		0.627
МУ-ын индексийн нэгдсэн оноо		0.612

Яамдын хувьд цахим ил тод байдлын хувьд дараах нийтлэг давуу болон сул тал ажиглагдаж байв.

СУЛ ТАЛ	ДАВУУ ТАЛ
Бүх яамны цахим хуудас нь технологийн хувьд нийцэл сайтай буюу ямар ч веб хөтөч болон хэрэгслээс хандах бүрэн боломжтой.	Ихэнх яаманд цахим ил тод байдлыг зохицуулдаг стандарт, дүрэм журам байдаггүй.
Бүх яамны цахим хуудсыг хайж олоход маш хялбар.	Цахим ил тод байдлыг хангах тусгай төсөв санхүүжилт байдаггүй эсвэл хангалтгүй.

Ихэнх яамны цахим хуудас “вэбсайтын бүтэц” буюу мэдээллийг хялбар олох зорилго бүхий хэсэгтэй.

Яамд цахим ил тод байдлынхаа гүйцэтгэлийг тогтмол хянан үнэлдэг ч тодорхой хэрэгсэл эсвэл үндсэн үзүүлэлтүүдээр хяналт хийх байдал хангалтгүй.

СУЛ ТАЛ	ДАВУУ ТАЛ
Байгууллагуудын ажилтнуудад цахим платформуудыг ашиглах боломж хангалттай нээлттэй байдаг.	Мэдээлэл түгээхэд зөвхөн цахим хуудас ашигладаг ба бусад платформ (нийгмийн онлайн сүлжээ, аппликейшин гм) ашиглах нь бага.
Байгууллагаас гаргасан шийдвэртэй холбоотой мэдээллийг ил тод нийтэлдэг. Бүх холбогдох тогтоол, журмыг цахим хуудаснаас харж болно.	Ихэнх яамны хувьд цахим хуудсан дээрээ оруулж буй мэдээллийн агуулга (үйл ажиллагаа, хүний нөөц, санхүү төсөв болон худалдан авалтын мэдээлэл) нь учир дутагдалтай.
Бүх ажилтныг компьютер болон интернэтээр бүрэн хангасан.	Цахим хуудсан дээр иргэдтэй шууд харилцах, тэдний санал, гомдлыг хүлээн авах хэсэг байхгүй.

Хэрэгжүүлэгч агентлагийн цахим ил тод байдал

Нийт үйл ажиллагаа явуулж буй 17 хэрэгжүүлэгч агентлагуудын цахим ил тод байдлыг үнэлсэн бөгөөд хэрэгжүүлэгч агентлагийн ангилал дотроо Ашигт малтмал, газрын тосны газар 0.718 оноогоор тэргүүлж байна. Нийт 5 хэрэгжүүлэгч агентлагийн цахим ил тод байдал хангалттай түвшинд байгаа бол үлдсэн 12 хэрэгжүүлэгч агентлагийн цахим ил тод байдал сул байна.

Хүснэгт 3 Индексийн үр дүн, хэрэгжүүлэгч агентлагууд

Эрэмбэ	Хэрэгжүүлэгч агентлаг	Оноо
1	Ашигт малтмал, газрын тосны газар	0.718
2	Гаалийн ерөнхий газар	0.715
3	Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газар	0.694
4	Татварын ерөнхий газар	0.673
5	Гадаадын иргэн харьяатын газар	0.652
6	Хөдөлмөр халамжийн үйлчилгээний ерөнхий газар	0.636
7	Шинжлэх ухаан, үйлдвэрлэл, инновацын газар	0.633
8	Иргэний нисэхийн ерөнхий газар	0.629
9	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар	0.614
10	Эрүүл мэнд, нийгмийн даатгалын ерөнхий газар	0.597
11	Гэр бүл хүүхэд залуучуудын хөгжлийн газар	0.554
12	Мал эмнэлгийн ерөнхий газар	0.528
13	Цаг уур орчны шинжилгээний газар	0.528
14	Биеийн тамир спортын газар	0.526
15	Соёл урлагийн газар	0.515
16	Архивын ерөнхий газар	0.504
17	Газар зохион байгуулалт геодези, зураг зүйн газар	0.465
Хэрэгжүүлэгч агентлагуудын дундаж:		0.599
Ерөнхий дундаж:		0.612

Хэрэгжүүлэгч агентлагуудын цахим ил тод байдлын хувьд дараах нийтлэг давуу болон сул тал ажиглагдаж байв.

ДАВУУ ТАЛ	СУЛ ТАЛ
Ихэнх байгууллагын цахим хуудсанд байгууллагын бүтцийн тухай мэдээлэл болон хэлтсийн дарга нарын нэр, утасны жагсаалт хангалттай багтсан.	Ихэнх байгууллагуудад цахим платформуудыг ашиглах боломж зөвхөн админ бүртгэлтэй ажилтанд л нээлттэй байдаг.
Байгууллагуудад тогтмол шинэчлэгдэж байдаг нээлттэй мэдээллийн сан байгаа.	Цахим ил тод байдлыг хангах чиглэлийн тодорхой хөтөлбөр, үйл ажиллагаа байдаггүй.
Ихэнх байгууллагууд нэгдсэн эсвэл тусгай сервертэй.	Ихэнх байгууллагууд зөвхөн дотооддоо сургалт хийдэг.
Мэдээлэл удирдлагын дата платформ ихэнх агентлагуудад байгаа бөгөөд энэ нь нэвтрэхэд хялбар.	Ихэнх байгууллага цахим ил тод байдлынхаа гүйцэтгэлийг тогтмол хянан үнэлдэггүй.
Ихэнх агентлагууд ажлын байрны зарыг тогтмол мэдээлэлдэг.	Цахим хуудасны бүтэц хэсэг байхгүй учир мэдээлэл олоход хүндрэлтэй.
Нийгмийн сүлжээ рүү холбогдох холбоос бүх агентлагуудын цахим хуудсанд багтсан.	Цахим хуудас дээрх ил тод байдлын хэсэг хангалтгүй.

Тохируулагч агентлагийн цахим ил тод байдал

Нийт үйл ажиллагаа явуулж буй 8 тохируулагч агентлагуудын цахим ил тод байдлыг үнэлсэн бөгөөд тохируулагч агентлагийн ангилал дотроо Харилцаа холбоо, мэдээллийн технологийн газар 0.674 оноогоор тэргүүлж байна. 1 тохируулагч агентлагийн цахим ил тод байдал хангалттай түвшинд байгаа бол үлдсэн 7 хэрэгжүүлэгч агентлагийн цахим ил тод байдал сул байна.

Хүснэгт 6 Индексийн үр дүн, тохируулагч агентлагууд

Эрэмбэ	Тохируулагч агентлаг	Оноо
1	Харилцаа холбоо мэдээллийн технологийн газар	0.674
2	Онцгой байдлын ерөнхий газар	0.626
3	Мэргэжлийн хяналтын ерөнхий газар	0.602
4	Цагдаагийн ерөнхий газар	0.591
5	Үндэсний хөгжлийн газар	0.580
6	Хил хамгаалах ерөнхий газар	0.573
7	Стандарт хэмжилзүйн газар	0.569
8	Шударга өрсөлдөөн хэрэглэгчийн төлөөх газар	0.426
	Тохируулагч агентлагуудын дундаж:	0.579
	Ерөнхий дундаж:	0.612

Тохируулагч агентлагуудын цахим ил тод байдлын хувьд дараах нийтлэг давуу болон сул тал ажиглагдаж байв.

ДАВУУ ТАЛ	СУЛ ТАЛ
Ихэнх байгууллагад цахим ил тод байдлыг зохицуулдаг стандарт, дүрэм журам байдаг	Цахим ил тод байдал бий болгох төсөв санхүүжилт хангалтгүй
Бусад төрийн байгууллагуудын цахим хуудас руу орох холбоосыг бүх агентлагууд өөрийн цахим хуудсандаа байршуулсан	Ихэнх байгууллагад цахим ил тод байдлыг бий болгоход зорьж ажилладаг тусгай албан ёсны мэргэжилтэн байдаггүй. Ихэнх тохиолдолд үндсэн үүргээс гадна тухайн ажлыг хийж гүйцэтгэдэг.
Ихэнх байгууллагууд иргэдээс тогтмол санал зөвлөмж авч, үүнийхээ дагуу арга хэмжээ авч эгэх холбоотой ажилладаг Олон нийтэд түгээх мэдээллийн хүрээг нарийн тодорхойлж, үүнийгээ байгууллагын ажилтнуудын дунд сайн мэдээлэлдэг	Ихэнх байгууллагын мэргэжилтнүүд МТХ болон цахим ил тод байдлын сургалтуудад хамрагддаггүй Цахим хуудасны бүтцийн хэсэг байхгүй, түүнчлэн гадаад хэл дээрх мэдээллүүд хангалтгүй Вэбсайт дээрээ статистик мэдээллүүд оруулдаггүй.
Цахим хуудсанд ямар ч хөтчөөс хандах боломжтой	Шууд харилцах боломжит хэрэгсэл байхгүй.
Порталын агуулга хангалттай Ихэнх агентлагууд тусгай эсвэл нэгдсэн сервертэй	Цахим хуудас дээрх ил тод мэдээллийн хэсгүүд маш хангалтгүй.

Аймгийн засаг даргын тамгын газрын цахим ил тод байдал

Нийт 21 аймгаас 19 аймгийн засаг даргын тамгын газар (ЗДТГ)-ын цахим ил тод байдлыг үнэлсэн бөгөөд аймгийн ЗДТГ-ын ангилал дотроо Дундговь аймгийн ЗДТГ 0.774 оноогоор тэргүүлж байна. Нийт 6 аймгийн ЗДТГ-ын цахим ил тод байдал хангалттай түвшинд байгаа бол үлдсэн 13 аймгийн ЗДТГ-ын цахим ил тод байдал сул байна.

Хүснэгт 7 Индексийн үр дүн, аймгууд

Эрэмбэ	Аймгийн ЗДТГ	Оноо
1	Дундговь аймаг	0.774
2	Өвөрхангай аймаг	0.769
3	Дархан-Уул аймаг	0.733
4	Өмнөговь аймаг	0.711
5	Говь-Алтай аймаг	0.695
6	Дорноговь аймаг	0.670
7	Увс аймаг	0.664
8	Хэнтий аймаг	0.658
9	Булган аймаг	0.637
10	Архангай аймаг	0.636

Эрэмбэ	Аймгийн ЗДТГ	Оноо
11	Сэлэнгэ аймаг	0.634
12	Сүхбаатар аймаг	0.583
13	Хөвсгөл аймаг	0.582
14	Говьсүмбэр аймаг	0.558
15	Завхан аймаг	0.540
16	Баянхонгор аймаг	0.534
17	Төв аймаг	0.482
18	Ховд аймаг	0.465
19	Дорнод аймаг	0.413
	Аймгийн ЗДТГ-ын дундаж:	0.618
	Ерөнхий дундаж:	0.612

Аймгийн ЗДТГ-ын цахим ил тод байдлын хувьд дараах нийтлэг давуу болон сул тал ажиглагдаж байв. Нийтлэг давуу талын хувьд аймгууд төдийлөн бага байсан ч **Дундговь, Өвөрхангай** гэх эрэмбийн эхний аймгууд нийт аймгийн дунджийг нэмэгдүүлж өгсөн байна.

ДАВУУ ТАЛ	СУЛ ТАЛ
Ихэнх аймгийн ЗДТГ иргэдээс тогтмол санал зөвлөмж авч, үүнийхээ дагуу арга хэмжээ авах байдлаар эгэх холбоотой ажилладаг.	Ихэнх аймгууд төсөвтөө цахим ил тод байдлыг хангахад чиглэсэн зардал тусгадаггүй.
Ихэнх аймгууд дата баз зохицуулах болон үүсгэх чадвартай бүхий ажилтантай.	Гаднаас сургалт авах боломж бага байдаг учир ихэнхдээ дотооддоо сургалт зохион байгуулдаг.

Байгууллагын цахим ил тод байдлыг бий болгох стратегийн төлөвлөгөө/хөтөлбөр ихэнх аймгуудад байдаг.

Ихэнх аймгууд дотоод болон гадаад үнэлгээ нь дээр тулгуурласан цахим ил тод байдлыг сайжруулах үйл ажиллагааны төлөвлөгөөг боловсруулж хэрэгжүүлдэггүй.

Үзүүлж буй үйлчилгээний тухай мэдээллийг цахим хуудастаа хангалттай байршуулдаг.

Ихэнх байгууллага цахим ил тод байдлынхаа гүйцэтгэлийг тогтмол хянан үнэлдэг боловч тодорхой арга хэрэгсэл, гүйцэтгэлийн үндсэн үзүүлэлтүүдийг ашигладаггүй.

Байгууллагаас гаргасан шийдвэрүүдийн тухай мэдээллийг хангалттай оруулдаг.

Мэдээлэл түгээхэд зөвхөн вэбсайт болон олон нийтийн сүлжээг ашигладаг ба бусад хэрэгслүүдийг ашигладаггүй.

Нийгмийн сүлжээ рүү холбогдох холбоосыг хангалттай байршуулсан.

Ихэнх аймгуудад мэдээлэл удирдлагын /data management/ платформ байхгүй.

ДАВУУ ТАЛ	СУЛ ТАЛ
	Цахим хуудсанд гадаад хэл дээрх мэдээлэл байхгүй.
	Цахим хуудсанд ил тод байдлын хэсгүүд байгаа хэдий ч дотор нь мэдээлэл байхгүй тохиолдол олон гарсан.
	Шууд харилцах боломж бүхий хэсэг байхгүй.

Дүүргийн засаг даргын тамгын газрын цахим ил тод байдал

Нийт 7 дүүргийн засаг даргын тамгын газрын цахим ил тод байдлыг үнэлсэн бөгөөд дүүргийн ЗДТГ-ын ангилал дотроо Чингэлтэй дүүргийн ЗДТГ 0.684 оноогоор тэргүүлж байна. Нийт 2 дүүргийн ЗДТГ-ын цахим ил тод байдал хангалттай түвшинд байгаа бол үлдсэн 5 дүүргийн ЗДТГ-ын цахим ил тод байдал сул байна.

Хүснэгт 8 Индексийн үр дүн, дүүргүүд

Эрэмбэ	Дүүргийн ЗДТГ	Оноо
1	Чингэлтэй дүүрэг	0.684
2	Налайх дүүрэг	0.678
3	Баянгол дүүрэг	0.620
4	Багахангай дүүрэг	0.619
5	Сүхбаатар дүүрэг	0.616
6	Баянзүрх дүүрэг	0.612
7	Багануур дүүрэг	0.580
	Дүүргүүдийн ЗДТГ дундаж:	0.630
	Ерөнхий дундаж:	0.612

ДАВУУ ТАЛ	СУЛ ТАЛ
Бүх дүүргүүд цахим ил тод байдлыг бий болгох тусгай албан ёсны үүрэг бүхий мэргэжилтэнтэй.	Ихэнх байгууллагад цахим ил тод байдлыг бий болгох тодорхой стратегийн төлөвлөгөө/хөтөлбөр байхгүй хэдий ч энэ чиглэлээр ажлууд хийгддэг.
Ихэнх дүүргийн ЗДТГ иргэдээс тогтмол санал зөвлөмж авч, үүнийхээ дагуу арга хэмжээ авах байдлаар эгэх холбоотой ажилладаг.	Гаднаас сургалт авах боломж бага байдаг учир ихэнхдээ дотооддоо сургалт зохион байгуулдаг.
Нийгмийн сүлжээ рүү холбогдох холбоосыг цахим хуудсандаа хангалттай байршуулсан.	Ихэнх байгууллагууд дотоод болон гадаад үнэлгээ нь дээр тулгуурласан цахим ил тод байдлыг сайжруулах үйл ажиллагааны төлөвлөгөөг боловсруулж хэрэгжүүлдэггүй.
Бүх дүүргүүд ажлын байрны мэдээллийг тогтмол мэдээлэлдэг.	Цахим хуудасны бүтэц цэс байхгүй мөн гадаад хэл дээр мэдээлэл оруулдаггүй.

ДАВУУ ТАЛ	СУЛ ТАЛ
Бүх дүүргүүд байгууллагаас гаргасан шийдвэрийн тухай тогтмол мэдээлэлдэг	Ил тод байдлын мэдээлэл хангалтгүй.
Бүх дүүргүүдийн цахим хуудас дотоод хайлтын системтэй	Шууд харилцах хэсэг цахим хуудас дээр байдаггүй.

Парламентын харьяа байгууллагын ил тод байдал

Нийт 9 парламентын харьяа байгууллагын цахим ил тод байдлыг үнэлсэн бөгөөд парламентын харьяа байгууллагын ангилал дотроо Монгол банк 0.719 оноогоор тэргүүлж байна. Нийт 5 парламентын харьяа байгууллагын цахим ил тод байдал хангалттай түвшинд байгаа бол үлдсэн 4 парламентын харьяа байгууллагын цахим ил тод байдал сул байна.

Хүснэгт 9 Индексийн үр дүн, Парламентийн харьяа байгууллагууд

Эрэмбэ	Парламентын харьяа байгууллагууд	Оноо
1	Монгол банк	0.719
2	Авлигатай тэмцэх газар	0.688
3	Хүний эрхийн үндэсний комисс	0.672
4	Үндэсний статистикийн хороо	0.664
5	Улаанбаатар хотын захирагчийн алба	0.653
6	Санхүүгийн зохицуулах хороо	0.636
7	Үндэсний аудитын газар	0.601
8	Сонгуулийн ерөнхий хороо	0.516
9	Төрийн албаны зөвлөл	0.486
Парламентийн харьяа байгууллагууд:		0.626
Ерөнхий дундаж:		0.612

Парламентын харьяа байгууллагуудын цахим ил тод байдлын хувьд дараах нийтлэг давуу болон сул тал ажиглагдаж байв.

ДАВУУ ТАЛ	СУЛ ТАЛ
Байгууллагын ажилтнуудыг компьютер болон интернэтэд холбогдох боломжоор бүрэн хангасан.	Цахим хуудасны бүтэц хэсэг ихэнх парламентын харьяа байгууллагуудад байхгүй.
Байгууллага бүр тусгай эсвэл нэгдсэн сервертэй.	Цахим хуудас дээрх ил тод байдлын хэсэг хангалтгүй, зарим мэдээллүүдийг дутуу оруулсан.
Байгууллагаас гаргасан шийдвэрийн тухай тогтмол мэдээлэлдэг.	Цахим хуудас дээр шууд холбоо барих хэсэг байхгүй.

5. ДҮГНЭЛТ, САНАЛ ЗӨВЛӨМЖ

Хууль эрх зүйн орчин

Хууль эрх зүйн орчны бүрэлдэхүүн хэсгийн үр дүнг тооцож гаргахдаа хуулийн болон бусад олон улсын үзүүлэлтүүдийн үр дүнг ашиглан боловсруулсан. МУ-ын төрийн байгууллагуудын хувьд цахим ил тод байдлыг бий болгох, сайжруулахтай холбоотой үндсэн баримт бичиг байгаа ч, бодлого, стратеги нь тохиромжгүй, хэрэгжилт сул байна.

Засаглалын үр дүнг гаргахдаа Дэлхийн банкны “Дэлхийн засаглалын индекс” болон түүний бүрэлдэхүүн хэсгүүдийн үр дүнг ашигласан бөгөөд Монгол Улс дунджаас бага зэрэг дээгүүр оноотой байсан бол эрх зүйн орчны дэд бүлгүүд дундаа засаглал хамгийн бага үзүүлэлттэй байв. Ялангуяа засаглалын нэг гол үзүүлэлт болох хуулийн хэрэгжилт сул байна. Энэ үзүүлэлтээр тухайн улс оронд хууль өдөр тутам, практикт хэрхэн хэрэгжиж байгааг, олон нийт хэрхэн мэдэрч, хүлээн авч байгааг үнэлдэг. Түүнээс гадна засгийн газрын үр ашгийн үзүүлэлт тааруухан үр дүнтэй гарсан бөгөөд энэ нь төрийн үйлчилгээ, төрийн алба, бодлого боловсруулалт, хэрэгжилтийн чанарыг үнэлсэн олон улсын үзүүлэлт юм. Эдгээр засаглалын гол үзүүлэлтүүд тааруу байгаа нь мэдээлэл авах эрх бүрэн хангагдаагүй буюу суурь механизм нь хангалттай бүрдээгүй байгааг харуулж байна. Харин *Иргэний нийгэм* дэд бүлгийн хамгийн сул индикатор нь тухайн улс оронд болж буй үйл явдал, чиг хандлагад иргэний нийгмийн байгууллагуудын хандах хандлага, тулгамдсан асуудал, бэрхшээлд анхаарч, нөлөөлж буй байдал зэргийг харгалзсан үзүүлэлт юм.

Эрх зүйн орчны бүрэлдэхүүн хэсгийн мэдээллийг үнэлэхэд манай улсын хувьд хуулийн нэгдсэн цахим хуудастай (www.legalinfo.mn) байсан нь давуу тал болж байв.

Байгууллагын чадамж

Байгууллагын чадамж бүрэлдэхүүн хэсгийг үнэлэхдээ тухайн байгууллагын мэдээллийн ил тод байдал буюу цахим хуудас хариуцсан албан хаагчидтай холбогдож мэдээлэл авсан.

Мэдээлэл цуглуулсан байгууллага бүрд цахим хуудас хариуцсан албан хаагч байсан нь өөрөө их эерэг үр дүн байв. Гэсэн хэдий ч байгууллагын нөөцийн хүртээмж болон манлайлал зэрэг индикаторууд харьцангуй тааруу байсан нь тухайн хариуцсан албан хаагчийн үйл ажиллагаагаа тасралтгүй сайжруулах, цаашид энэ чиглэлдээ хөгжих, сурч боловсроход сөрөг нөлөө үзүүлж байгаа үр дүн гарсан. Энэ нь тухайн ажилтны дотоод болон гадаад сургалт авах үзүүлэлт харьцангуй бага байгаагаар баталгаажиж байна.

Цаашлаад *Цахим нээлттэй байдлын* оноотой харьцуулахад *Байгууллагын чадамжийн* бүрэлдэхүүн хэсгийн оноо бага зэрэг өндөр байгаа хэдий ч эдгээр байгууллагын нөөцийн хүртээмж, манлайлал, албан хаагчийн үүрэг хариуцлагын хэсгүүд сул байгаа нь дараагийн бүрэлдэхүүнд буюу ил тод мэдээллийн агуулгын чанар, албан хаагчийн гүйцэтгэлийн үр дүнд нөлөөлж байв.

Байгууллага бүрд цаашид үйл ажиллагаандаа тусгана уу гэж дараах санал зөвлөмжийг хүргэж байна. Үүнд:

- Мэдээллийг ил тод болгохтой холбоотой байгууллагын удирдлагын манлайллыг сайжруулах, албан хаагчдад үүнээс гарч болох давуу тал, үр нөлөөг ойлгуулах, соён гэгээрүүлэх суурь хэрэгцээ хангагдаагүй байна.
- Цахим ил тод байдлыг хангахад тусгайлан чиглэсэн дотоод төлөвлөгөөтэй болох хэрэгцээ шаардлага их байна. Ихэнх байгууллага жилийн төлөвлөгөөндөө тухайн ажлыг тусгадаг хэдий ч уг ажлыг хэрэгжүүлэх тусгай төлөвлөгөөгүй ажиллаж байна. Ингэснээр тухайн ажилд зарцуулагдах төсөв, хөрөнгө болон бусад нөөцүүд хомс байгааг анхаарч, өөрчлөх боломжтой үүснэ.
- Мэдээлэл болон цахим хуудсан дах мэдээллийн ил тод байдлыг үнэлэх, хянах тодорхой, зориулагдсан үзүүлэлт буюу хяналтын механизмтай болох шаардлагатай.
- Байгууллагын цахим хуудасны ил тод байдал хариуцсан мэргэжилтнийг сургалтуудад хамруулах, тухайн ажилтны энэ чиглэлийн мэдлэг, ур чадварыг сайжруулахад анхаарч ажиллах хэрэгцээ байсаар байна. Мөн мэдээллийн ил тод байдлыг хариуцсан орон тооны ажилтангүй, эсвэл бусад ажил үүрэгтэй хавсран хийдэг байдлыг өөрчилж албажуулах шаардлагатай.

Цахим нээлттэй байдал

Цахим нээлттэй байдлын бүрэлдэхүүн хэсгийн хувьд үнэлгээнд хамрагдсан байгууллага бүр идэвхтэй ажиллаж буй цахим хуудастай байсан. Эдгээр цахим хуудас нь ямар ч хөтчөөс (internet explorer, firefox, chrome) хайсан шууд илэрсэн. Үүнээс гадна Монгол улсын Засгийн газрын цахим хуудсанд (www.zasag.mn) бүх төрийн байгууллагын цахим хуудаснуудын мэдээлэл багтсан, тухайн холбоосоор шууд холбогдох боломжтой зэрэг нь хэрэглэгчид олоход амар, хялбар байдлыг бий болгож байна.

Ихэнх цахим хуудаснууд мэдээллийн төрөл, ангиллаар тусдаа цэсүүдтэй, хаанаас ямар мэдээллийг авах боломжтой талаар ойлгомжтой бүтэцтэй байсан. Гэсэн хэдий ч тухайн цэсэд оруулсан мэдээллийн агуулга дутуу, хоосон буюу огт мэдээлэл оруулаагүй эсвэл тухайн мэдээллийн шинэчилсэн байдал тодорхойгүй бөгөөд удаан хугацаанд шинэчлээгүй зэрэг нийтлэг дутагдал байв. Тухайлбал 'Шилэн дансны тухай' хуулийн хэрэгжилтийн хүрээнд төсвийн ил тод байдлыг хангах тусдаа хэсэг цахим хуудас бүрд байршсан ба агуулгын хувьд өнгөрсөн жилийн зардал, тухайн жилийн төсөв, худалдан авах ажиллагааны төлөвлөгөө зэрэг мэдээллийн ил тод байдал хангалттай сайн байлаа. Харин сар, улирал тутмын зардал, аудит төсвийн тодотгол, үйлчилгээний үнэ зэрэг хуульд заагдсан тавигдсан байх шаардлагатай цаг үеийн мэдээллүүдийг байршуулсан байдал хангалтгүй буюу ил тод бус байв.

Үнэлгээний үр дүнд үндэслэн, цаашид байгууллагууд цахим хуудсаа сайжруулахад ашиглагдах дараах санал зөвлөмжүүдийг хүргэж байна. Үүнд:

- Байгууллагууд мэдээллийн ил тод байдал болон мэдээлэл авах эрхийн тухай хуульд заагдсан үйл ажиллагаа, хүний нөөц, төсөв санхүү, худалдан авах

ажиллагаатай холбоотой бүх төрлийн нээлттэй мэдээллийг зүйл заалт тус бүртэй нь тулгаж дутуу мэдээллийг нөхөж оруулах, шинэчлэхэд анхаарал хандуулах шаардлагатай.

- Хуульд заагдсан буюу хэрэглэгчид авах боломжтой бүх төрлийн мэдээ, баримт бичиг, гэрээ хэлэлцээртэй холбоотой мэдээллийн бэлэн байдлыг хангаж, аль болох нээлттэй байршуулах хэрэгтэй.
- Мэдээлэл бүрд нийтлэгдсэн, шинэчилсэн хугацааг оруулах. Хэрэглэгч тухайн цахим хуудасны мэдээллийг хуучирсан мэдээлэл эсэхийг хянах, үнэлэх боломжгүй, мэдээлэл оруулсан хугацаа нь тодорхойгүй тохиолдлууд элбэг байна.
- Олон нийтийн сүлжээний суваг байгаа бол заавал үүнийг цахим хуудсанд дээрээ холбож өгөх шаардлагатай. Ингэснээр хэрэглэгчийн мэдээлэл авах сувгийг нэмж өгнө.
- Цахим хуудасны бүтцийн сонголтыг олоход хялбар, ойлгомжтойгоор байршуулах. Энэ нь цахим хуудаснаас мэдээлэл хайж олоход хүндрэлтэй байгаа асуудлуудыг шийдвэрлэнэ.
- Байгууллагын дүрэм, журам, баримт бичгүүдийг цахим хуудсанд олон нийтэд нээлттэй, ил тод байхаар оруулж өгснөөр тухайн байгууллага, албан хаагчидтай холбоотой үндсэн чиг үүрэг, зорилго, үйл ажиллагаа, үйл явц зэрэгтэй холбоотой харилцааг зохицуулахад дэмжлэг үзүүлэх юм.
- Цахим хуудас бүрд тухайн байгууллагатай холбоо тогтоох, санал хүсэлт илгээх хэсгийг нээлттэй оруулж өгснөөр хэрэглэгчидтэй харилцах, эгэх хариуцлагыг нэмэгдүүлэх боломжийг бүрдүүлнэ.

ХАВСРАЛТ

Хавсралт 1. Дэлгэрэнгүй арга зүй

Цахим ил тод байдлын индекс нь нэгдмэл нэг оноогоор илэрхийдэгдэх бөгөөд энэ нь Эрх зүйн орчин, Байгууллагын чадамж, Цахим нээлттэй байдал гэсэн 3 бүрэлдэхүүн хэсгээс бүрдэнэ. Эдгээр бүрэлдэхүүн хэсгүүд нь 9 дэд бүлэг, 26 индикатораас бүрдэнэ. Индикатор бүр дотроо тодорхой хэмжээний асуултуудаас бүрдэнэ.

Бүрэлдэхүүн хэсэг, дэд бүлэг, индикаторуудын задаргаа болон жингийн тооцооллыг доорх хүснэгтээс харах боломжтой.

Зураг 5 Бүрэлдэхүүн хэсэг, дэд бүлэг, индикатор тус бүрийн жин

ЭРХ ЗҮЙН ОРЧНЫ (1/3)		БАЙГУУЛЛАГЫН ЧАДАМЖ (1/3)		ЦАХИМ ИЛ ТОД БАЙДАЛ (1/3)				
МЭДЭЭЛЭЛ АВАХ ЭРХ (1/3) ➤	ЗАСАГЛАЛ (1/3) ➤	ИРГЭНИЙ НИЙГЭМ (1/3) ➤	БАЙГУУЛЛАГЫН БЭЛЭН БАЙДАЛ (1/3) ➤	ҮҮРЭГ ХАРИУЦЛАГА (1/3) ➤	МХТ-ийн АШИГЛАЛТ (1/3) ➤	ТЕХНОЛОГИ (0.13) ➤	НЭЭЛТТЭЙ МЭДЭЭЛЛИЙН АГУУЛГА (0.80) ➤	ИРГЭДИЙН ОРОЛЦОО БА ХАРИЛЦАА (0.07) ➤
Мэдээлэл авах эрх (1/12)	Хуулийн хэрэгжилт (1/12)	Иргэдийн ороцоо (1/9)	Ил тод байдлыг хангах процедур ба процесс (1/6)	Манлайлал (1/6)	МХТ-ийн ашиглалт (1/9)	Технологийн нийцтэй байдал (0.07)	Үйл ажиллагаа (0.16) Хүний нөөц (0.16)	Харилцаа ба эргэх холбоо (0.07)
Мэдээллийн хүрээ (1/12)	Дуу хоолой ба хариуцлага (1/12)	Хэвлэл мэдээллийн эрх чөлөө (1/9)	Нөөцийн хүрэлцээ (1/6)	Тасралтгүй хөгжил ба сургалт (1/6)	МХТ-ийн хүрэлцээ (1/9)	Технологийн үр нөлөөтэй байдал (0.07)	Төсөв санхүү (0.24) Худалдан авах ажиллагаа (0.18)	
Мэдээлэл хүсэх процедур (1/12)	Зохицуулалтын чанар (1/12)	Иргэний нийгмийн төлөв байдал (1/9)			Мэдээллийн санг үүсгэх, засварлах чадвар (1/9)		Нээлттэй өгөгдөл (0.07)	
Мэдээллийн сангц ба хамгаалалт (1/12)	Засгийн газрын үр нөлөөтэй байдал (1/12)							

Цахим ил тод байдлын индексийн 3 бүрэлдэхүүн хэсэг тус бүр ижил жинтэй байхын тулд “1/3” байна. Бүрэлдэхүүн хэсэг бүр мөн адил 3 дэд бүлэгт хуваагдаж байгаа ба эдгээр бүлэгт багтах индикаторуудын оруулж буй хувь нэмрээс хамааран жинг тооцоолно.

Эрх зүйн орчны бүрэлдэхүүн хэсэг дэх Мэдээлэл авах эрх болон Засаглалын дэд бүлгүүдийн индикаторууд тус бүр 1/12 жинтэй ($1/3 \div 4$), Иргэний нийгмийн дэд бүлгийн индикатор тус бүр 1/9 жинтэй ($1/3 \div 3$) байна. Байгууллагын чадамж бүрэлдэхүүн хэсгийг дээрх зарчмын адил тооцоолсон бол Цахим нээлттэй байдал бүрэлдэхүүн хэсгийн жинг индикаторуудын асуултын тоо болон дэд бүлэгт оруулах хувь нэмэр зэрэгт нь үндэслэн өөрөөр тооцоолсон. Цахим нээлттэй байдлын бүрэлдэхүүн хэсгийн хувьд нийт 45 асуулттай байгаа ба үүнийг задалбал Технологийн дэд бүлэг 6, Нээлттэй мэдээллийн агуулга 36, Иргэдийн оролцоо ба харилцаа 3 асуулттай байна. Ингэснээр эдгээр дэд бүлгүүд тус бүр 0.13 (6/45), 0.8 (33/45) болон 0.12 (3/25) гэж жинлэгдэж байна. Энэ бүрэлдэхүүн хэсгийн индикаторууд өмнөх хоёр бүрэлдэхүүнтэй адил байдлаар тооцоологдоно. Жишээлбэл, Технологи дэд бүлгийн Технологийн нийцтэй байдал дэд бүлгийн хувьд 3 асуултаас бүрдэж байгаа учир 0.07 (3/45) жинтэй байна. Хэрвээ индикатор доторх асуултын тоо өөрчлөгдвөл дээр аргаар жинг хувааж тооцоолно.

Эрэмбэ	Байгууллагууд	Индексийн нэгдсэн оноо	Эрх зүйн орчин	Байгууллагын чадамж	Цахим нээлттэй байдал
1	Дундговь аймаг	0.774	0.657	0.940	0.724
2	Өвөрхангай аймаг	0.769	0.657	0.859	0.790
3	Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам	0.753	0.657	0.845	0.756
4	Дархан-Уул аймаг	0.733	0.657	0.910	0.632
5	Сангийн яам	0.732	0.657	0.917	0.622
6	Монгол банк	0.719	0.657	0.818	0.680
7	Ашигт малтмал, газрын тосны газар	0.718	0.657	0.864	0.631
8	Гаалийн ерөнхий газар	0.715	0.657	0.720	0.769
9	Өмнөговь аймаг	0.711	0.657	0.932	0.544
10	Говь-Алтай аймаг	0.695	0.657	0.872	0.556
11	Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газар	0.694	0.657	0.760	0.666
12	Авлигатай тэмцэх газар	0.684	0.657	0.833	0.562
13	Чингэлтэй дүүрэг	0.684	0.657	0.873	0.521
14	Налайх дүүрэг	0.678	0.657	0.873	0.502
15	Харилцаа холбоо мэдээллийн технологийн газар	0.674	0.657	0.675	0.689
16	Татварын ерөнхий газар	0.673	0.657	0.827	0.534
17	Хүний эрхийн үндэсний комисс	0.672	0.657	0.903	0.456
18	Хөвсгөл аймаг	0.670	0.657	0.731	0.623
19	Эрүүл мэндийн яам	0.667	0.657	0.797	0.546
20	Зам, тээврийн хөгжлийн яам	0.665	0.657	0.746	0.590
21	Үндэсний статистикийн хороо	0.664	0.657	0.880	0.455
22	Дорноговь аймаг	0.664	0.657	0.699	0.634
23	Булган аймаг	0.658	0.657	0.717	0.600
24	Эрчим хүчний яам	0.655	0.657	0.541	0.767
25	Гадаадын иргэн харьяатын газар	0.652	0.657	0.753	0.544
26	Улаанбаатар хотын захирагчийн алба	0.650	0.657	0.836	0.456
27	Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын яам	0.639	0.657	0.804	0.456
28	Увс аймаг	0.637	0.657	0.686	0.569
29	Санхүүгийн зохицуулах хороо	0.636	0.657	0.807	0.445
30	Хэнтий аймаг	0.636	0.657	0.616	0.636

Эрэмбэ	Байгууллагууд	Индексийн нэгдсэн оноо	Эрх зүйн орчин	Байгууллагын чадамж	Цахим нээлттэй байдал
31	Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газар	0.636	0.657	0.626	0.623
32	Архангай аймаг	0.634	0.657	0.754	0.491
33	Шинжлэх ухаан, үйлдвэрлэл, инновацын газар	0.633	0.657	0.744	0.499
34	Иргэний нисэхийн ерөнхий газар	0.629	0.657	0.501	0.730
35	Онцгой байдлын ерөнхий газар	0.626	0.657	0.663	0.558
36	Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам	0.624	0.657	0.617	0.598
37	Баянгол дүүрэг	0.620	0.657	0.559	0.644
38	Багахангай дүүрэг	0.619	0.657	0.620	0.579
39	Сүхбаатар дүүрэг	0.616	0.657	0.603	0.589
40	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар	0.614	0.657	0.561	0.624
41	Баянзүрх дүүрэг	0.612	0.657	0.681	0.499
42	Мэргэжлийн хяналтын ерөнхий газар	0.602	0.657	0.603	0.546
43	Үндэсний аудитын газар	0.601	0.657	0.768	0.378
44	Гадаад хэргийн яам	0.597	0.657	0.644	0.489
45	Эрүүл мэнд, нийгмийн даатгалын ерөнхий газар	0.597	0.657	0.627	0.505
46	Цагдаагийн ерөнхий газар	0.591	0.657	0.548	0.569
47	Сэлэнгэ аймаг	0.583	0.657	0.348	0.744
48	Сүхбаатар аймаг	0.582	0.657	0.684	0.404
49	Багануур дүүрэг	0.580	0.657	0.559	0.524
50	Хил хамгаалах ерөнхий газар	0.573	0.657	0.548	0.513
51	Стандарт, хэмжил зүйн газар	0.569	0.657	0.627	0.423
52	Үндэсний хөгжлийн газар	0.569	0.657	0.549	0.501
53	Хууль зүй, дотоод хэргийн яам	0.568	0.657	0.659	0.389
54	Говьсүмбэр аймаг	0.558	0.657	0.472	0.544
55	Байгаль орчин, аялал жуулчлалын яам	0.556	0.657	0.489	0.523
56	Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам	0.556	0.657	0.554	0.456
57	Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газар	0.554	0.657	0.719	0.286
58	Завхан аймаг	0.540	0.657	0.450	0.512
59	Баянхонгор аймаг	0.534	0.657	0.534	0.410
60	Мал эмнэлгийн ерөнхий газар	0.528	0.657	0.528	0.528

Эрэмбэ	Байгууллагууд	Индексийн нэгдсэн оноо	Эрх зүйн орчин	Байгууллагын чадамж	Цахим нээлттэй байдал
61	Цаг уур, орчны шинжилгээний газар	0.528	0.657	0.703	0.222
62	Биеийн тамир спортын газар	0.526	0.657	0.499	0.423
63	Барилга, хот байгуулалтын яам	0.517	0.657	0.694	0.200
64	Сонгуулийн ерөнхий хороо	0.516	0.657	0.333	0.558
65	Соёл урлагийн газар	0.515	0.657	0.444	0.443
66	Архивын ерөнхий газар	0.504	0.657	0.444	0.411
67	Төрийн албаны зөвлөл	0.486	0.657	0.524	0.276
68	Төв аймаг	0.482	0.657	0.492	0.295
69	Ховд аймаг	0.465	0.657	0.000	0.312
70	Газар зохион байгуулалт геодези, зураг зүйн газар	0.465	0.657	0.315	0.422
71	Шударга өрсөлдөөн хэрэглэгчийн төлөөх газар	0.426	0.657	0.442	0.178
72	Дорнод аймаг	0.413	0.657	0.438	0.144